

ТҮҮХ, СОЁЛ,
БОЛОВСРОЛ,
ШАШИН

**ОЙРАД МОНГОЛЧУУДЫН
ТҮҮХЭЭС ӨГҮҮЛЭХ НЬ**

Ч. Далай

Нэг.

Монгол туургатны салшгүй бүрэлдэхүүн хэсэг Алун-гоогийн үр сад Ойрад монголчууд бол эртнийхээ уламжлалт ёс заншлаа орхиогүй хадгалсан өвөрмөц соёл иргэншилтэй, хатан зоригтой, хурц ухаантай, тэвчээр хатуужилтай, их хөдөлмөрч ард түмэн юм. Ойрадын түүх гэдэг нь монгол үндэстний түүхийн нэгэн бүрэлдэхүүн хэсэг мөн. Ойрад гэдэг тусгай үндэстэн ястан байгаагүй. Тэр тусмаа үндэсний цөөнх буюу монголын бага ястан ч биш. Түүхээс Монгол туургатан улс маань хоёр үндсэн хэсгээс л бүрдэж байсан. Энэ нь дээр үедээ бол талын иргэн (Нирун монгол), Ойн иргэн (Ойрад); Сүүлдээ Дорнод Монгол (төв монгол) Баруун монгол (Ойрад голдуу) хоёр хэсэг болно. Гэхдээ алтан ургийнхнаар тэргүүлсэн төв монгол нь монгол туургатан улсын гол цогцос болж ирснийг үгүйсгэвэл түүх гуйвуулсан хэрэг болно. Монголын түүхийг монгол туургатан ард түмэн цөмөөрөө л хамтран бүтээж, Монгол төр улсаа хамтын хүчээр байгуулж, байгуулсан төр улсаа хамтын тэмцлээр манаж хамгаалж байсан. Одоо ч тэр уламжлал хэвээрээ л хэвшин үргэлжлэх учиртай. Харийн хатган үймүүлэх хорт бодлогод хэт хууртан Монголын зарим ноёрхогч ангийн богино жолоот бодлогоос болж монгол туургатаны эл хоёр гол хүчний хооронд элэг эмтрэн эмгэнэлт явдал үе үе гарч байлаа. Ийм явдал түүхэнд дахин давтагдах учиргүй билээ. Чингис хаан бол нийт Монгол туургатнаа дээд, доод гэж ялгахгүйгээр нэгэн адилд үзэж, нэгдэл нягтралыг ихэд эрхэмлэдэг хүн байлаа. Энэ бол монголын түүх судлах хүмүүст гол чиглэл болох ёстой юм.

Чингисийн нэгдсэн улсаас хойш ялангуяа Манжийн үед Ойрад Монголын ард түмэн их ч зовж зүдэрсэн, салж сарнисан, ад үзэгдэж явсан удаатай билээ. XVII зууны сүүлчээс XVIII зууны дунд үе хүртэл монголчуудын тусгаар тогтнолын эцсийн гал голомтын төлөө 60 гаруй жил дангаараа шахам цус урсган тэмцсэн ард түмэн юм. Эх орон, газар шороо, тусгаар тогтнолынхоо төлөө харийн эзлэн түрэмгийлэгчийн эсрэг тэмцсэн ард түмэнд хэзээ ч буруугүй билээ. Тэдний түүх нэг үе гуйвагдаж ирсэн боловч ирээдүйд чин үнэнээр дүгнэгдэн бичигдэх нь зайлшгүй. Өнөө үе хүртэл монгол туургатан тэр ард түмний түүхийг чин үнэнээр нэгтгэн дүгнэж бичсэн зохиол бүтээл ч ховорхон байна.

Ойрад монголчууд дэлхийд их тархжээ. Өнөөгийн байдлаар олонхи нь БНХАУ-д оршин амьдарч байна. Шинжаан, Хөх Нуур, Ганьсугийн умарт зах Хулан уулын орчим болон ӨМӨЗО-ы Алашаа аймагт зан заншлаа сүрхий хадгалсан ойрад монголчууд бий. Зөвлөлт улсын бүрэлдэхүүнд Элэстэйн Халимаг гэж нэрлэгдсэн Дөрвөд голдуу нэлээд ойрад хүн байна. Халимагаас тасарсан цөөн тооны ойрад хүн Америкт оршин сууж байна. БНМАУ-ын баруун гурван аймаг Ховд,

Увс, Баян-Өлгийд ойрад монголчууд болох Дөрвөд, Баяд, Захчин, Урианхай, Торгууд, Өөлд, Мянгад ястан оршин суудаг. Үүнээс 1989 оны тоогоор Дөрвөд 55200, Баяд 39200, Захчин 23000, Урианхай 21300, Торгууд 10100, Өөлд 9200, Мянгад 4800 хүн байна. Галдан Бошогтын дайнаар Архангай, Өвөрхангайн заагт ирж нутагшсан цөөн тооны Өөлд хүмүүс одоо хүртэл тэндээ амьдарч байна. Жич, Цагаадай, Өгөөдэйн захирч байсан улс оронд цэргийн алба хаах журмаар буюу албат ардаар татагдан очиж суурьшиж байгаад лал шашинтанд уусан хайлсан хүмүүсийг эс оролцуулбал өнөө үед дэлхийд 800000 шахам Ойрад монгол хүн байх шиг байна.

«Монголын нууц товчоо», Рашид-ад-Дины «Судрын чуулган», «Юаньши» зэрэг эртний сурвалж зохиол болон ойрад Монголчуудын доторхи домог, аман уламжлал, бас мэр сэр үлдэж хоцорсон тод үсгийн түүх судраас үзвэл Ойрад монголчуудын өвөг дээдэс эртнээс нааш Байгаль, Хөвсгөл нуур, Сэлэнгийн адаг, Тагна, Соёны нуруу, Горлог (Енисей), Эрчис мөрний эх, Алтайн уулсын ой тайгыг даган оршихдоо мал маллахаас гадна бас гөрөөлөн, загасчлан амь зуугчид цөөн бус байжээ. Харин тэдний дотроос зарим хэсэг нь газар тариалан эрхлэх болсон нь нэлээд хожмын явдал болой.

Ойрад гэдэг нэр Х зууны үеэс түүхэнд тодорхой болж эхэлсэн бололтой юм. Ойрад гэдэг үг дээр үедээ арай өөрөөр дуудагдаж байсан байх. Магад ч үгүй нутгийнхаараа Өөрөд, Өлхнийхэн,¹ Өөлөд, Өгөлэй гэх мэтээр дуудагдаж байсан байж болох. Ойрад гэдэг үгийг Хятадаар зургаа, долоон янз тэмдэглэсэн байдаг. Юань (1260—1368), Мин (1368—1644), Манж (1616—1911) -ийн үед өөр өөр аялгуугаар дуудаж болох дүрс үсгээр тэмдэглэжээ². Тэдгээрээс Мин улсын үед нэрлэсэн «Ва-ла», Манжийн үед тэмдэглэсэн «Вэй-ла-тэ» гэдэг хоёр нэрээр л голдуу түүхэнд тэмдэглэж иржээ. Зарим үед хятад сударт «да ва-ла» («Их Ойрад») гэж бичсэн үзэгдэнэ. Ер нь эрдэмтэд Ойрад гэдэг нэрийн утгыг эрж сурвалжлан янз бүрээр тайлбарлаж иржээ. Тэдгээрийн дотроос зонхилох нөлөө үзүүлж ирсэн тайлбар хоёр байдаг. Нэг нь «Ойр дотно», «Ойр худын», «Ойрын холбоо» гэсэн утгатай гэх. Нөгөө нь «Ойн иргэн», «Ойд амьдрагчид» гэсэн утгаас үүссэн гэнэ. Ойрадын түүхийг судалсан олонхи эрдэмтэн голдуу сүүлчийн саналыг баримтлаж иржээ. Гэвч эдгээр тайлбарыг яг баталгаатай гэх үндэс бас байхгүй. Ойрад гэдэг нэрийн утгыг нарийвчлан судлах талаар сүүлийн үед БНХАУ-ын монгол эрдэмтэд чармайлт гаргаж үнэтэй санаа оноо дэвшүүлж байна.³ Анхандаа Ойрад гэдэг үг газрын нэрнээс ч гарсан байж болох, бас Зонхилогч эзэн хүний нэрээр ч нэрлэсэн байж болох юм. Ямар ч гэсэн дөрвөн Ойрадын голлох ястны нэрээр Ойрад гэж нэрлэгдсэн нь дамжиггүй бизээ.

Ойрад Монголын түүхтэй холбогдолтой сурвалж хэрэглэгдэхүүн тийм элбэг биш ч гэсэн Монгол, Төвд, Хятад, Манж, Орос хэлээр бичсэн түүх шастир, дурдатгал, замын тэмдэглэл, захидал, илгээлт, өргөдөл, зарлиг захирамж гэх мэт үнэ цэнэтэй ховор хэрэглэгдэхүүн бас ч гэж чамлалтгүй хадгалагдан үлдсэн байна. Ойрад Монголын талаар монгол, Хятадаар байхгүй ховор хэрэглэгдэхүүн төвд хэлээр байгааг ашиглах цаг нэгэнт болжээ. Дээрх олон хэлний хэрэглэгдэхүүнийг гүйцэд харьцуулан судалж эл ард түмний түүхийг дэгсдүүлж догсдуулахгүйгээр үнэн зөв дүгнэн бичих явдал юм.

Хятадын Мин улс ялангуяа Манж гүрний үеийн хятад, манж, бичиг зохиолд нарийвчилсан судалгаа хийхгүйгээр шууд үг үсэггүй ишлэл авч хуулах байдлаар ашиглавал үнэнд гүйцэд нийцэхгүй ерөөсгөл судалгаа болно. Жишээлбэл, Манж гүрний эзэн хаад өөрт нь бууж

өгөхгүй олон жил тэмцсэний өшөөг авахаар 1755-1758 онд Ойрад Монголыг хүйс тэмтрэн устгах, суугуул нутаг уснаас нь хөөж тараах зэрэг ихээхэн хилэнцэт ажиллагаа явуулсан юм. 1757 оны эмгэнэлт явдал ойрад монгол хүний зүрхэнд эгнэгт шингэсэн байдаг. Тэр жил Тэнгэр Тэтгэсэн хааны зарлигаар хэдэн түмэн Ойрад хүнийг амьдаар газар булж, олон олон өрх айлыг хотыг нь харлалтал арчин устгаж ялангуяа дөрвөн Ойрадын тэмцлийг хошуучилж байсан Өөлд ястанг үзэгдсэн газарт нь тарчлаан алж байжээ. Монголоор бичсэн өдий төдий ном судрыг нэг ч хуудас үлдээхгүй шахам шатаасан билээ. Тэр үед ялсан нь Манжийн эзэн хаан болж ялагдсан нь Ойрадын ард түмэн болов. Иймээс ялалт байгуулсан тал хэмээгч нь өөрийн сүр хүчийг хуурамчаар магтан дэвэргэж ялагдсан ч ялснаар, буруудсан ч Зөвдсөнөөр дүрсэлсэн байна. Нөгөө төр улсынхаа тусгаар тогтнолын төлөө шудрага тэмцэл үргэлжлүүлж байсан ойрад монголчууд «Ялагдагч» болж тэдний байгуулсан гавьяа, ялалт цөмөөр хараар дүрслэгдэн «урвагчид», «тэрслэгчид», «Их гэр бүлийг бутраагчид», «самуун дэгдээсэн хулгайч нар» гэх мэт нэр хоч өгч түүх сударт шургалуулжээ. Тэмцлийн манлайд явсан Галдан Бошогт, Амарсанаа нарт Нохой, гахай гэхээс өөр нэр бараг үлдсэнгүй. Энэ нь 1663—1722 оны үйл явдлыг тэмдэглэсэн Энх-Амгалан хааны «ши-лу» («үнэн түүх») 1736—1795 оны хэрэг явдлыг тэмдэглэсэн Тэнгэр Тэтгэсэн хааны «Ши-Лу» («үнэн түүх»-д, тод томруун тусгалаа олжээ. Манж гүрний үед гарсан бүх түүх, архивын хэрэглэгдэхүүн эдгээр хаадын «үнэн түүх»-ийн агуулгаар л бичигдсэн байна. Ийм л сурвалжид үг дуугүй хөтлөгдвөл хир зэрэг бодит үнэнд нийцсэн түүх бичигдэх нь ойлгомжтой. Гэхдээ хятад хэлээр бичсэн тэр олон сурвалжийн үнэ цэнийг бүрмөсөн үгүйсгэж болохгүй нь мэдээж билээ.

Өнгөрсөн үед Ойрадын судалгааг хийхдээ Монгол, Төвд, Хятад, Манж, Оросоор бичсэн ном зохиол, архивын хэрэглэгдэхүүнийг гүйцэд ашиглахгүй зарим нэг олдсон хэрэглэгдэхүүндээ хэт автагдан өрөөсгөл талтай судалгаа явуулж ирснийг дээр нэгэнт өгүүлсэн билээ. Тухайлбал хятад түүхчид монгол, төвд, манж, орос хэлний ном зохиол бараг үзэхгүйгээр дан хятад сурвалжаа түшиглэн судалгаа хийж иржээ. Тиймээс тэд зохиол бүтээлээ голдуу хятад төвийн үзлээр бичсэн нь харагдана. 80-аад оноос БНХАУ-д хэвлэгдсэн «Чжун гар ши лүэ» («Зүүнгарын товч түүх»)⁴, «Чжунгар ди ди-ли юй Вэнь-у» («Зүүнгарын түүх ба соёлын дурсгал»)⁵, «Вэйлутэ Мэнгу ши лун чжи» («Өөлд (Ойрад) монголын түүхийн өгүүллүүд»)⁶, «Вэйлатэ ши Лүн-вэнь чжи» («Ойрадын түүхийн өгүүллийн эмхэтгэл»)⁷ зэрэг сүүлийн үеийн хэдэн номоос үзэхэд л зарим нь бас л ийм байна. Гэхдээ Ойрадын судлалд хятадын эрдэмтдийн оруулсан хувь нэмэр багагүй юм. 1985 онд Бээжинд «Зүүнгарын товч түүх» хэмээх зохиол Хятадаар хэвлэгдсэн нь И. Я. Златкины «Зүүнгарын хаант улсын түүх» зохиолын дараа гарсан хоёрдахь дорвилог бүтээл гэж үзэлтэй. Гэхдээ энэ зохиолд бидний үзэл баримтлалтай таарахгүй санаа дүгнэлт цөөнгүй байна.

Сүүлийн үед БНХАУ-д Ойрадын судалгааг өргөн хүрээтэй хийж эхлэв. Манжийн хаадын архиваас түүвэрлэн авч эмхэтгэсэн «Зүүнгарын түүхийн хэрэглэгдэхүүний түүвэр»⁸ гэдэг сурвалж зохиол Бээжинд хэвлэгдэв. Хөлөн Буйрт «Ойрадын түүхийн сурвалж»⁹ гэдэг чухал ном монголоор хэвлэгдэн гарав. «Ойрад цааз»-ыг дэлгэрэнгүй тайлбартайгаар 1986 онд Хөх хотод хэвлэн гаргав. «Өвөрмонголын багшийн их сургууль» сэтгүүл 1987 оны нэмэлт дугаараа дан Ойра-

дын судлалд зориулан гаргажээ. Шинжааны Үрэмч хотод Ойрадын судлалын төв байгуулагдав. Тэнд Жангар судлалыг хамгийн сайн хийж байна. Жамц, Бадам нар хариуцан хоёр боть Жангарыг тод үсгээр хэвлүүлэв.¹⁰ 80-аад оноос «Хан тэнгэр» гэдэг эрдэм шинжилгээний сэтгүүл тод үсгээр хэвлэгдэн гарч түүнд олон арван сонирхолтой өгүүлэл, хэрэглэгдэхүүн нийтлэгдэв. 1989 оноос «Ойрадын судлал»¹¹ сэтгүүл Үрэмчид хэвлэгдэн гарав. Чухам ингэж БНХАУ-ын Монгол эрдэмтэд Ойрадын судлалд зүтгэл гаргаж бодитой хувь нэмэр оруулсаар байна. Энэ талаар Дорнотив,¹² Алтан-Оргил,¹³ Ринчиндорж,¹⁴ Намсрай,¹⁵ Жамц,¹⁶ Норов,¹⁷ Цорс Эрдэнэбаяр,¹⁸ Тогтох, Одон¹⁹ нарын олон эрдэмтэнг нэрлэж болох байна. Тэдний судалгааны давуулаг тал гэвэл хятад сурвалжийг монгол сурвалжтай харьцуулан судалж бас дээрээс нь тод сурвалж арвин ашигласанд оршино.

Ойрад монголын түүх судлахад «Баатар Увааш Түмний туурвисан дөрвөн Ойрадын түүх»,²⁰ «Гаван Шаравын тууж хэмээх оршивой»,²¹ «Хоо өрлөгийн түүх»,²² «Дөрвөн Ойрадын түүх тууж хэмээн оршивой»,²³ «Монголын уг эхийн түүх»,²⁴ «Торгууд хаадын түүх»,²⁵ «Үнэн сүжигт хуучин Торгууд хийгээд Чин сэтгэлт шинэ торгуудын хаад ноёдын уг үндэсний илтгэл түүхийн бичиг»²⁶ зэрэг нь чухал үнэтэй хэрэглэгдэхүүн болох юм. Голдуу тодоор бичигдсэн эдгээр сурвалжийг БНХАУ-д худам монголоор хэвлэн гаргасан нь судалгаанд их дөхөм үзүүлэв.

БНМАУ-ын номын санд «дөрвөн ойрадын түүх» тодоор, «дөрвөн ойрадын түүх намтар» монголоор хадгалагдаж байна. Ер нь Б.Буян чуулганы бичсэн «дөрвөн ойрадын түүх»²⁷, Д. Гонгорын «Ховдын түүх»²⁸ Н.Ишжамцын «Монголын ард түмний 1755—1758 оны тусгаар тогтнолын зэвсэгт тэмцэл»²⁹-ээс өөр Ойрад Монголын түүхийг тусгайлан бичсэн ном зохиол БНМАУ-д одоогоор хараахан гараагүй байна. Манай түүхчид БНМАУ-ын түүхийг бичихдээ Ойрад Монголын түүхийн хэсгийг их товчхон дурьдах төдий л өнгөрсөн байдаг. Тэр ч байтугай зарим түүхэн үйл явдлыг үнэн мөнөөр дүгнээгүй байдал ч харагддаг. Энэ нь тэр талын ном хэрэглэгдэхүүн дутуу дулим ашигласан буюу хятад, манж, төвд, тод сурвалж бараг ашиглаагүйгээс болсон бизээ. Харин зохиолч Ж. Пүрэв «Зүрхний хилэн», «Манан будан» академич Ш.Нацагдорж «Болор толь», сэтгүүлч Цэмбэл «Амарсанаа» роман бичиж тус тус нийтлүүлэв. Эдгээр зохиолуудад Ойрад Монгол ард түмний тусгаар тогтнолын тэмцлийг толгойлж байсан гол баатруудын дүрийг зоригтой хөндсөнөөр онцлог юм. Зохиогчид сайн зохиол туурвих гэж их хүчин зүтгэл гаргасан нь илт харагдана. Гэхдээ Ойрад Монгол ард түмний тэмцлийн үнэн түүх, тэмцлийг толгойлсон Галдан Бошогт, Амарсанаа нарын үнэн дүрийг гүйцэд гаргаж чадаагүй байна. Энэ нь түүхийн мэдлэг дутсаных. Ер нь роман зохиол бол өргөн олны хүртээл болж олон түмэнд үнэмшил амархан төрүүлдэг, ялангуяа залуу үеийг эх оронч үзлээр хүмүүжүүлэхэд ихээхэн хамаатай учраас монголын түүхээр бичих аливаа уран зохиолд их ул суурьтай хандаж, түүх гуйвуулах буюу хиймэл дүр оруулахгүйгээр ганцхан «Монгол» гэдэг нийтлэг сэтгэлээр л бичих нь цорын ганц баримтлах зөв арга юм. Сүүлийн үед Ойрадын түүхээр Очир, Г.Минис, аман зохиолоор Ж. Цолоо³⁰, Жангар судлалаар А. Нарантуяа нар амжилттай ажиллаж байна. Өнөө үед БНМАУ-д Ойрадын түүхийг сайн судалж монголынхоо түүхийг үнэн зөвөөр шинэ сэтгэлгээгээр баяжуулах цаг нэгэнт болжээ. БНМАУ-ын номын сангуудад 2000 шахам дэвтэр тод ном, хэрэглэгдэхүүн хадгалагдаж байна. Ойрадын судлалыг бий болгох, тод үсгийн

ном цуглуулах ажилд эрдэмтэн Х. Лувсанбалдан ихээхэн хүч чармайлт гаргасан юм.

Орос, Зөвлөлтийн эрдэмтэд Ойрадын түүх судлалд бодитой хандив оруулж ирсэн юм. Гэхдээ тэд голдуу оросын архивт л тулгуурласан нь үзэгдэнэ. Эрдэмтэн Иакинф,³¹ В. Успенский,³² В. Л.Котвич,³³ В. В.Бартольд,³⁴ Д.Банзаров,³⁵ Б. Я.Владимирцов, И. Я. Златкин³⁶ нарын Ойрадын судлалаар бичсэн ном зохиол дэлхийд нэрд гарсан юм Ялангуяа И. Я. Златкин шиг Ойрад Монголын түүхийг үнэн зөв дүгнэж бичсэн эрдэмтэн ховор бизээ. Японы эрдэмтэд Ойрадын судалгааг чамбай сайн хийдэг. Өрнө зүгийн эрдэмтдийн бүтээл миний хувьд одоогоор тодорхой бус байна. Олдсон зарим зүйлийг уншихад тэд Ойрадыг голдуу Халимаг Монгол гэдгээр авч бичдэг бололтой юм. Ойрадын түүхээс өгүүлэх нь гэдэг цуврал өгүүллийн оршил болгож бичсэн нь энэ бөлгөө.

(Үргэлжлэл дараагийн дугаарт)

¹ Өлхнийхэн гэдэг нь өвөрлөгчид, уулын өврийнхэн гэсэн утгатай ойрад монгол хэл юм.

² Хятадаар «Ойла», «Вэйла», «Вэйлутэ», «Вайлатэ», Вала, Вэйлатэ гэх мэт аялгуугаар дуудаж болох дүрс үсгээр тэмдэглэсэн байдаг. Харамсалтай нь хэвлэлийн байдлаас болж энэ удаа хятад дүрс үсгийг бичиж болсонгүй.

³ Тогтох «сурвалжийг хайх таван өгүүлэмж», «Өвөр монголын багшийн их сургууль» сэтгүүлийн 1987 оны нэмэлт дугаарт, 1987 онд «Өвөр Монголын баг шийн их сургууль сэтгүүл нь ойрадын судлалаар бүтэн дугаар гаргажээ.

⁴ 1985 онд Бээжингийн ардын хэвлэлийн газраас эрхлэн Чжунгар Ши лүэ» («Зүүнгарын товч түүх») зохиол хэвлэжээ. 6 бүлэг 20 зүйлд хувааж бичсэн 326 тал хуудастай энэхүү зохиол нь Зүүнгарын хаант улсын түүхийг ихэд дэс дараатайгаар хураангуйлан дүгнэж бичсэн эрдэм шинжилгээний чамбай зохиол болжээ. Хятад сурвалжийг гүйцэт сайн ашиглажээ. Хятад төвийн үзлээр л бичсэн болох нь илэрхий байна.

⁵ 1984 онд Хөх нуурын ардын хэвлэлийн хорооноос Ван Хунчжун, Лю Жужун нарын бичсэн «Чжунгар ди дили юй вэнь-у» («Зүүнгарын түүх ба, соёлын дурсгал») гэдэг номыг хэвлэн гаргажээ. 186 тал хуудастай энэ зохиолд Ойрадын түүхийн чухал сэдвээр 17 өгүүлэл нийтлэгджээ. Хамгийн чухал нь уул ном Ойрадын түүхтэй холбоотой 45 нэр төрлийн түүхийн дурсгал зураг оржээ. Тэдний дотор шинэ соргог хэрэгтэй зураг хэд хэд байна.

⁶ 1984 онд Хөх Нуурын ардын хэвлэлийн хорооноос эрхлэн Ойрадын түүх судлаач Ма Дачжэн нарын бичсэн Вэйлутэ мэнгү ши лүн чжи(Өөлөд монголын түүхийн өгүүллүүд) гэдэг 279 тал хуудастай зохиол хэвлэжээ. Номонд 1691 онд Галдан Бошогтоос Оросын цагаан хаанд бичсэн нэгэн захианы эх нийтэлжээ. (монголоор)

⁷ 1987 онд Шинжааны багшийн их сургуулиас эрхлэн хэвлүүлсэн «Вайлатэ шилунь-Вэнь чжи» («Ойрадын түүхийн өгүүллийн эмхэтгэл») гэдэг 50 тал хуудастай зохиол нь 23 эрдэмтний өгүүллээс бүрджээ.

⁸ 1987 онд Шинжааны Нийгмийн шинжлэх ухааны академийн үндэстний судлалын хүрээлэнгээс эрхлэн 1836--1910 оны хооронд дахь Манжийн 11 хааны «ши «лу» («Үнэн түүх») -гээс Ойрадын холбогдолтой хэсгийг түүвэрлэн эмхэтгэж нэг боть ном болгон хэвлэсэн нь Ойрад монголын судлалд үнэтэй ажил болжээ.

⁹ 1985 онд Өвөр Монголын соёлын хэвлэлийн хорооноос эрхлэн Бадай, Алтан Оргил, Эрдэнэ нарын эмхэтгэсэн «Ойрадын түүхэн сурвалж бичиг» хэмээх чухал зохиол монголоор хэвлэн гаргав.

¹⁰ Шинжаанд Тод үсгээр Жамц. То. Бадам нарын эмхэтгэсэн 2 боть Жангар хэвлэгдэн гарав. Дараа нь худам монголоор дахин хэвлэгджээ.

¹¹ Үрэмчид хэвлэгдсэн «Ойрадын судлал», 1989 оны 1-2, 1990 онд 1-2 дугаар хэвлэгдэв. Ойрадын судлалд үнэтэй хувь нэмэр оруулах тогтмол хэвлэл ажээ.

¹² Дорнотив, «Монголын хууль цаазын түүхэн дэх Ойрадын цаазын байр суурь 1987 оны Өвөр Монголын багшийн их сургууль сэтгүүлийн нэмэлт дугаарт монголын түүхээр олон бүтээл хэвлүүлж байна. Өвөр Монголд Ойрадын судлалыг толгойлон ажиллаж байна.

13 Эрдэмтэн Алтан-Оргил Ойрад монголын түүхээр олон бүтээл хэвлүүлж байна. Өвөр монголд Ойрадын судлалыг толгойлон ажиллаж байна.

14 Эрдэмтэн Ринчиндорж Ойрад монголчуудын дунд орж аман зохиол цуглуулах гавьяатай үйлсийг эхлэн хийлцэв.

15 Намсрай, «Галдан Бошогт» 1987, Хөх хот. Ойрадын түүхийг их сайн судалж байгаа эрдэмтэн

16 Жамц, Шинжаанд Ойрадын судлал ялангуяа Жангар судлалыг удирдаж байгаа авьяаслаг эрдэмтэн

17 Шинжаан их сургуулийн багш Норов бол Ойрад монголын түүхийг хамгийн сайн мэддэг эрдэмтэн байх. Хэвлэгдсэн хэвлэгдээгүй олон ном, өгүүлэл бичжээ. «Ойрадын үүсэл хөгжилтэй холбогдох зарим асуудал гэдэг түүний бичсэн илтгэл их сонирхолтой юм

¹⁸ Цорс Эрдэнэбаяр ирээдүйд Ойрадын судлалаар их зүйл бүтээх залуу эрдэмтэн гэдэг нь мэдэгдэж байна.

¹⁹ Одон «Эсэн хаан», Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1983, Хөх хот

²⁰ Хошуудын ноён баатар Увааш Түмэний зохиосон «дөрвөн Ойрадын түүх» хэмээх тодоор бичсэн гар бичмэл судар Шинжааны Шаливаа гэгээнээс зээлэн аз зарим хүн хуулан авчээ. 1956 онд тэр зохиолын нэгэн хуулбарыг Шинжаанаас Мэргэнбаатар олж авч иржээ. Ингээд 1956 онд Тосон бараар хэвлэжээ. Бүрэн эхээр нь 1985 онд Өвөр Монголд хэвлэжээ. Баатар Увааш Түмэн, «Дөрвөн Ойрадын түүх гар бичмэл түүх БНМАУ-ын ШУА-ийн Хэл, зохиолын хүрээлэнгийн гар бичмэл— номын хөмрөгт бий.

²¹ Гаван Шаравын «Дөрвөн Ойрадын түүх» хэмээх зохиолыг 1956 онд Мэргэн баатар Шинжаанаас олж ирээд Өвөр Монголын нийгмийн ШУА-ийн номын санд хадгалжээ. Гэвч тэр эх соёлын хувьсгалын үед үгүй болжээ. 1962 онд Эрдэгийн гар хуулбарыг үндэслэн нөхвөрлөн гүйцээж 1985 онд худам монголоор Өвөр Монголд хэвлэжээ. Энэ түүхийн тод үсгийн нэг эх Ленинградд хадгалагдаж буй.

²² Хоо өрлөг бол Хэрэйдийн Тооруул вангийн 7—9-р үе мөн бөгөөд Ижлийн Торгуудын ноён юм. Албат ардаа дагуулан 1629 онд дөрвөн Ойрадаас салан нүүж 1630 онд Ижилд хүрчээ. 1644 онд нас барсан. Хоо өрлөгийн түүхийг 1982 онд Шинжааны Баянголын монголчууд дотроос Норов багш олж авчээ. 1985 онд Өвөр Монголд хэвлүүлжээ.

²³ Энэ зохиолыг Х. Лувсанбалдан эрхлэн 1976 онд «Тод үсгийн дурсгалууд» хэмээх эмхэтгэлд оруулан Улаанбаатарт хэвлүүлжээ.

²⁴ Энэ зохиол «Хан тэнгэр, сэтгүүлийн 1983 оны 1 дүгээрт бүрэн эхээрээ нийтлэгджээ.

²⁵ БНХАУ-д хоёр төрлийн эх байдаг. Нэг нь Норов багшийн гарт хадгалагдаж байжээ. 1985 онд Өвөр Монголд бүрэн эхээр нь хэвлэн гаргав.

²⁶ Энэ зохиолын уг бичиг нь шар торгон гадартай, цагаан торгон дээр бичсэн байна. Хэргэм зэрэгтэй хүний нэрийг улаанаар, энгийн хүний нэрийг хараар бичжээ. Торгуудын ханы ордонд хадгалагдаж байсан бололтой юм. Уг зохиолыг Дорж гэдэг хүний гараас Бадай олж авчээ. 1985 онд Өвөр Монголд хэвлэгдэв.

²⁷ Б, Буянчуулган «Дөрвөн ойрадын түүх» — Галдан Бошогт хааны бүлэг. УНС бич; «Монголын бүх газар нутаг» УНС. бич., «Манжаас Монголыг эзэрхийлсэн үеийг илэрхийлсэн хэрэглэгдэхүүн 3 дэвтэр, Унс. бич. Эдгээр нь цөмөөр Ойрад монголын түүхтэй холбоотой юм.

²⁸ Доктор Д. Гонгор бол Ойрад монголын түүхийн сайн мэргэжилтэн байв. Ховдын түүх гэдэг номдоо Ховд аймагт суудаг Ойрадын түүхийг бузгай сайн бичжээ,

²⁹ Н. Ишжамц, Монголын ард түмний 1755 — 1758 оны тусгаар тогтнолын зэвсэгт тэмцэл (Амар-санаа, Чингүнжав нарын бослого) УБ., 1962, Доктор. Н. Ишжамц бол Монголын түүхчид дотроос анх түрүүн хятад, манж сурвалж ашиглан Ойрад Монголын түүхийн сэдвээр бичсэн эрдэмтэн юм.

³⁰ Ж. Цолоо, «Арван гурван хүлэгийн дуун» УБ., 1984. энэ эмхэтгэл дотор Ойрад Монголын эртний амьдрал ялангуяа манжийн эсрэг тэмцэж байсан тэмцлийг харуулсан хоёр гурван дуу байна.

³¹ Иакинф. Историческое обозрение ойратов или кальмыков с XV столетия до настоящего времени, Спб., 1829

³² В. Успенский Страна Кукэ-нор или Цин-хай с прибавлением краткой истории Ойратов и Монголов, ЗИРГО, т. 6, 1880

³³ В. Л. Котвич. Русские архивные документы по сношению с Ойратами в ХУП-ХУШ вв. ИРАН, Пг. 1919, N 12-15

³⁴ В. Бартольд. Очерки истории Семиречья. Фрунзе, 1943

³⁵ Д. Банзаров. Об ойратах и уйгурах. Т. 1. Казань, 1849

³⁶ И. Я. Златкин, История Джунгарского ханства Москва 1983